



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Зээлийн дугаар ба нэр: Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл 50091-002

Гэрээний дугаар ба нэр: GW-12: Ерөнхий боловсролын сургуулийн VI-VII ангийн сурагчдад төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлэн нийлүүлэх

Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдөр, 10 цаг 00 минут, Улаанбаатарын цагаар

1. Монгол Улсын засгийн газар нь Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү зээлийн хөрөнгийн тодорхой хэсгийг Ерөнхий боловсролын сургуулийн VI-VII ангийн сурагчдад төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлэн нийлүүлэх гэрээг санхүүжүүлэхэд зарцуулна.
2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос Ерөнхий боловсролын сургуулийн VI-VII ангийн сурагчдад төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлэн нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

№	Багцын дугаар	Сурах бичгийн нэршил
Багц 1	GW-12/01	Монгол хэл VI
		Эх хэл (Казак хэл) VI
		Уран зохиол VI
Багц 2	GW-12/02	Үндэсний бичиг VI
		Байгалийн ухаан VI
		Мэдээллийн технологи VI
Багц 3	GW-12/03	Түүх VI
		Англи хэл VI (CD-тэй)
Багц 4	GW-12/04	Дизайн технологи VI
		Математик VI
Багц 5	GW-12/05	Иргэний боловсрол VI
		Иргэний боловсрол VII
Багц 6	GW-12/06	Эх хэл /Казак хэл/ VII
		Дүрслэх урлаг VI-VII
Багц 7	GW-12/07	Хөгжим VI-VII (CD-тэй)
		Газар зүй VII
Багц 8	GW-12/08	Монгол хэл VII
		Уран зохиол VII
Багц 9	GW-12/09	Үндэсний бичиг VII
		Мэдээллийн технологи VII
		Биологи VII
Багц 10	GW-12/10	Математик VII
		Нийгэм судлал VII
Багц 11	GW-12/11	Физик VII
		Түүх VII
Багц 12	GW-12/12	Хими VII

		Англи хэл VII (CD-тэй)
Багц 13	GW-12/13	Дизайн технологи VII
		Орос хэл VII (CD--тэй)

3. Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугуйт горимын дагуу явуулах бөгөөд эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна.

Чадварын үндсэн шалгуур үзүүлэлт

Эрх бүхий нөхцөл	Тендерт оролцогч ба түншлэлийн гишүүд нь АХБ-ны эрх бүхий орны харьяат байна. Мөн сонирхлын зөрчил, төрийн өмчит аж ахуйн нэгжийн байдал болон АХБ ба НҮБ-ийн аюулгүйн зөвлөл хориг зэрэг тендерт оролцогчийн эрх бүхий нөхцөл (ТӨОЗ-ны 4-т заасан)-ийг харгалзан үзнэ. Монгол Улсын Сангийн яамны тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд орсон бол тендерт оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ.
Жилийн борлуулалт дундаж	Сүүлийн 3 жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ тус тендерийн санал болгож буй нийт үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.
Гэрээний туршлага	Сүүлийн 3 жилд үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан, ижил төстэй бараа нийлүүлсэн хамгийн багадаа 1 гэрээ хэрэгжүүлсэн туршлагатай байна. Гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага гэдэгт сурах бичгээс гадна Зургадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-ийн 3. Техникийн тодорхойлолт хэсэгт заасан техникийн шаардлагад нийцсэн бусад ном, гарын авлага хэвлэсэн туршлагыг тооцно.
Үйлдвэрлэлийн туршлага	Тендерт оролцогч хамгийн багадаа сүүлийн 3 жилийн турш ижил төстэй бараа буюу сурах бичиг, ном, гарын авлага хэвлэж ирсэн туршлагатай байна.
Санхүүгийн байдал	Сүүлийн 3 (2016, 2017, 2018 он) жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан (тайлан баланс, орлогын тайлан)-г үндэслэн тендерт оролцогч урт хугацаанд ашигтай ажиллаж байгааг болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлно. Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцно. Сүүлийн 2 жилд энэхүү зөрүү нь эерэг байвал зохино.
Мөнгөн гүйлгээний чадавх	Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйлгээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь тус тендерт санал болгож буй нийт үнийн дүнгийн 30%-тай тэнцүү буюу түүнээс дээш байна. Хүрэлцэхгүй тохиолдолд үлдэгдэл хөрөнгийг зээлээр бүрдүүлэх боломжтой бөгөөд олгох зээлийн хэмжээг тодорхой бичсэн банкны албан бичиг ирүүлнэ. Тендерт оролцогч банкны шугаман зээлд бүртгэгдсэн нь дээрх шаардлагад нийцсэн гэж үзнэ. Банкны албан бичигт хэрэв судалж үзэх, банкны нөхцөл шаардлагын дагуу зээл олгох боломжтой зэрэг зээл олгох эсэх нь тодорхой бус агуулга тусгасан байвал үүнийг шаардлага хангаагүй гэж үзнэ.
Шүүхийн зарга ба маргаан	Одоо хянан шийдвэрлэгдэж буй аливаа нэхэмжлэл, шаардлага, арбитрын ажиллагаа, эсхүл бусад төрлийн шүүхийн зарга, маргааны нийт хэмжээ нь тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн 50%-иас илүүгүй байна.

4. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас нэмэлт мэдээлэл авч, ажлын өдрүүдэд 8:30-17:30 цагийн хооронд урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцаж болно.
5. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 50,000 төгрөгтэй тэнцэх эргэн үл төлөгдөх хураамжийг төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөрийг Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн Төрийн сангийн 100900011858 дансанд тушаана. Баримт бичгийг мөнгө тушаасан баримтыг үндэслэн цаасаар олгоно. Тендерт оролцогч хүссэн тохиолдолд мэйлээр илгээж болно. Баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотойгоор ямар нэг хариуцлага хүлээхгүй.
6. Тендерийг 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 10:00 цаг эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ. Тендерийн хамт тендерийн баримт бичигт заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 10:20 цагт урилгын төгсгөлд заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.
7. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.

Тендер хүлээн авах этгээд: Р.Балжинням, Ерөнхий боловсролын бодлогын газрын мэргэжилтэн

Байгууллагын нэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Байгууллагын хаяг: Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр Давхар ба ерөөний дугаар: 5 давхар, 516-1 тоот

Хот дүүрэг: Улаанбаатар хот

Улс: Монгол Улс

Утас: 976-11-318131